**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2008 оны 10 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 362 | Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 232.2 дахь хэсэг Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2009 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, бүрдүүлэлтийн хэлтэс /Д.Баасан/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улсын гаалийн ерөнхий газрын даргын 2002 оны 454 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалыг 2009 оны 8 дугаар сарын 10 -ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА Д.ЦЭВЭЭНЖАВ

***2008 оны 362 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журам”-ын 3 дугаар хэсэгт ГЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 19-ний А/285 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсныг холбогдох хэсэгт тусган оруулсан.***
***Нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны А/285 дугаар тушаалыг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс дагаж мөрдөнө.***

**Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2009 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 3069 дугаарт бүртгэлтэй.**

.

Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны
362 дугаар тушаалын хавсралт

# УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ОНЦЛОГ БАРААНД ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ ХИЙХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Шинжлэх ухаан, техникийн ололт, газар нутгийн дүрс, зураг зүйн бусад материал, судалгаа, шинжилгээ, геологи, байгаль, амьтан судлал, палеонтологийн олдворын болон бусад бүх төрлийн дээж, сорьц зэрэг /цаашид “онцлог бараа” гэх/ барааг гаалийн хилээр нэвтрүүлэхэд энэ журмыг мөрдөнө.

1.2.Энэ журамд заагдаагүй бусад асуудлыг гаалийн хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

## Хоёр. Гаалийн бүрдүүлэлт

2.1.Онцлог бараа нэвтрүүлэх аж ахуйн нэгж, байгууллага “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг”-ийн маягтаар мэдүүлнэ.

2.2.Онцлог барааг гаалийн хилээр нэвтрүүлэх мэдүүлэгч тухайн асуудал хариуцсан яам, засгийн газрын агентлаг /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх /-аас тодорхойлолт авсан байна.

2.3.Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараа нь хэд хэдэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой байх тохиолдолд тодорхойлолтыг төрийн захиргааны холбогдох байгууллага тус бүрээс авна.

2.4.Төрийн захиргааны байгууллагын газар, хэлтсийн дарга, эсхүл түүний орлогч гарын үсэг зурж, уг байгууллагын тэмдэг дарсан тохиолдолд тодорхойлолтыг хүчин төгөлдөрт тооцно.

2.5.Тодорхойлолт олгосноос үүдэн гарах хариуцлагыг тодорхойлолт олгосон албан тушаалтан хүлээнэ.

2.6.Тодорхойлолтыг 3 хувь үйлдэх бөгөөд түүнийг олгосон байгууллагад онцлог барааг нэвтрүүлж буй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнд болон гаалийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагад тус бүр 1 хувь үлдэнэ.

2.7.Гаалийн байгууллагатай сүлжээнд холбогдсон байгууллагууд тодорхойлолтыг гаалийн байгууллагад сүлжээгээр ирүүлж болно.

2.8.Тодорхойлолт олгосон төрийн захиргааны байгууллага онцлог бараанд таних тэмдэг тавих буюу битүүмжилсэн байх шаардлагатай бөгөөд тэмдэг, битүүмжлэлийн хэв загварыг гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдсэн байна.

2.9.Тодорхойлолтод дурдсан нөхцөл, зорилгоор гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараанд “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу хяналт тавьж, бүрдүүлэлт хийнэ.

## Гурав. Тодорхойлолт олгох байгууллага

3.1. Онцлог барааг гаалийн хилээр нэвтрүүлэхэд төрийн захиргааны дараах байгууллагаас тодорхойлолт авсан байна:

3.1.1.Геологи, эрдэс баялагийн чиглэлээр хийгдсэн судалгааны дээж, материал, зураг, өрмийн болон бусад дээж, геологийн тайлан, мэдээлэл хадгалах хэрэгсэлд буулгасан судалгааны бичиглэл зэрэг - Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

3.1.2.Газрын тосны чиглэлээр хийгдсэн судалгааны материал, зураг, өрмийн болон бусад дээж, геологийн тайлан, мэдээлэл хадгалах хэрэгсэлд

буулгасан судалгааны бичиглэл зэрэг - Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

3.1.3.Батлан хамгаалах асуудалтай хамааралтай судалгаа шинжилгээ, газар нутгийн загвар дүрс, зураг зүйн материал - Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

3.1.4.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, химийн бодисын дээж, сорьц -Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

3.1.5.Ураны хүдэр, түүний баяжмал, цацраг идэвхт химийн элемент болон цацраг идэвхт изотоп /хуваагдагч буюу баялаг химийн элемент болон изотоп орно/, тэдгээрийн нэгдэл, тэдгээрийг агуулсан хольц, үлдэгдэл, БТКУС-ийн зүйл 28.44-т заасанаас бусад изотоп, тэдгээрийн химийн хувьд тодорхойлогдсон буюу органик биш нэгдэл зэргийн дээж, сорьц -Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

3.1.6.Лабораторийн болон үйлдвэрлэлийн зориулалтаар өсгөвөрлөх, үржүүлэх өвчин үүсгэгч нян, түүний хорны дээж, эрүүл хүний ийлдэс, оношлогоо эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай донорын цус, дархлалын хувирмал бэлдмэл, бичил биетний өсгөвөр, эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний дээж, сорьц -Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

3.1.7.Палеонтологийн болон археологийн олдворын дээж, сорьц - Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

3.1.8.Үнэт металл, эрдэнийн чулууны дээж - Үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулууны чанар тодорхойлох лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн сорьцын хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

3.1.9.Бүх төрлийн мал амьтны үр хөврөл, үржлийн өндөг, цус болон цусны ийлдэс, төрөл бүрийн эмгэг төрүүлэгч хорхой шавьж, бичил биетний өсгөвөр, амьтны хүүр, сэг, ялгадас, хөрс, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн зэргийн дээж, сорьц - Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

3.1.10.Архи, согтууруулах ундаа, тамхины дээж - Үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

***(Журмын энэхүү 3 дахь хэсгийг ГЕГ-ын даргын 2017 оны А/285 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан.)***

----оОо-----

Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 362 дугаар
тушаалаар батлагдсан журмын хавсралт

## ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ОНЦЛОГ БАРААНЫ ТОДОРХОЙЛОЛТ

200__ оны ___ сарын ___ өдөр Дугаар __________

| | | |
|---|---|---|
| 1. | Тодорхойлолт авч буй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний нэр, хаяг, регистр, утасны дугаар | |
| 2. | Гаалийн хилээр нэвтрүүлэх үндэслэл болох баримт, түүний дугаар /гэрээ, протокол, г.м./ | |
| 3. | Барааны нэр, тоо хэмжээ /ном, хэвлэмэл материалын хуудасны тоо хэмжээ г.м/, үнэ | |
| 4. | Барааны код | |
| 5. | Хилээр нэвтрүүлж буй зорилго, хугацаа | |
| 6. | Хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн төрөл, боомтын нэр | |
| 7. | Хилээр нэвтрүүлэх он, сар, өдөр | |
| 8. | Хүлээн авагчийн хаяг | |

Зөвшөөрөл олгосон:

Байгууллагын нэр____________________

Тэмдэг_______________/албан тушаалтны нэр/____________/гарын үсэг/

Гаалийн мэдүүлгийн дугаар ______________________________________________

/ ГУБ-ын гарын үсэг, хувийн дугаар бүхий тэмдэг/_________________________